



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2004 оны 8 сарын 31 өдөр

Дугаар 297

Улаанбаатар

Гадаадад суралцуулах тухай

"Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2004 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн хурлын тэмдэглэл, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын 2,6-г үндэслэн ТУШААХ НЬ:

1. Чимиддорж овогтой Даваа, Цэрэн овогтой Нямдорж нарыг ОХУ-ын ДЯЯ-ны Санкт-Петербург хотын Хуулийн Их сургуулийн адъюнктурт 3 жилийн хугацаагаар, Ариунхүү овогтой Бат-Эрдэнийг Англи улсын Лондон хотын Технологи, менежментийн сургуулийн магистрантурт мэдээллийн технологийн чиглэлээр 1.5 жилийн хугацаагаар, Лхагважав овогтой Цогтбаатарыг АНУ-ын Калифорнийн Улсын Их сургуулийн магистрантурт эдийн засгийн чиглэлээр, Цэнд овогтой Содбаярыг БНХАУ-ын Шанхайн Их сургуулийн магистрантурт олон улсын бизнес, худалдааны чиглэлээр, Даш овогтой Бямбасүрэнг АНУ-ын Калифорнийн Шинжлэх ухаан, Менежментийн Их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр, Амар овогтой Түвшинжаргалыг АНУ-ын Вирджиния Олон Улсын Их сургуулийн магистрантурт эдийн засаг, бизнесийн удирдлагын чиглэлээр, Агваандорж овогтой Мөнхдөлийг АНУ-ын Калифорнийн Их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр, Оросоо овогтой Оюунчимэгийг АНУ-ын Калифорнийн Их сургуулийн магистрантурт эдийн засгийн чиглэлээр, Гүрбадам овогтой Үнэнбатыг АНУ-ын Калифорнийн Улсын Их сургуулийн магистрантурт төрийн захиргааны удирдлагын чиглэлээр, Бадарчин овогтой Эрдэнэбатыг Австрали улсын Канберрагийн Их сургуулийн магистрантурт хүний нөөцийн удирдлагын чиглэлээр, Энхээ овогтой Одбаярыг АНУ-ын Питсбургийн Их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлага, маркетингийн чиглэлээр, Дагвадаш овогтой Дулмааг Япон улсын Сендай хот дахь Олон улсын соёл судлалын их сургуулийн магистрантурт олон улсын эдийн засгийн чиглэлээр тус тус 2 жилийн хугацаагаар 2004-2005 оны хичээлийн жилээс суралцуулсугай.

Сайдын 140-ны сарын 1-ны өдрийн 6 дугаар тушаалаар

2. ХБНГУ-ын Берлин хотын Гумбольдтын Их сургуулийн докторантурт суралцаж буй Гансүх овогтой Цэрэнчунтын суралцах хугацааг 1 жилээр, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсын Бирмингэм хотын Их сургуулийн докторантурт суралцаж буй Ядамсүрэн овогтой Энхтуяагийн суралцах хугацааг 2 жилээр, Англи улсын Лондон хотын Худалдааны сургуулийн магистрантурт суралцаж буй Энхбат овогтой Энхнарангийн суралцах хугацааг хагас жилээр тус тус сунгасугай.

3. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.



САЙД / *Samunda* А.ЦАНЖИД